



ДОРНОД АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 112

Чойбалсан

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн албаны ёс зүйг дээдлэх зорилтот жилийн хүрээнд байгууллагын албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлага, байгууллагын соёлыг сайжруулах үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталж, зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Гантуяа –Эрүүл мэндийн газрын дэргэдэх Төрийн албан хаагчийн ёс зүйн зөвлөлийн гишүүн

Гишүүд: Г.Урангэрэл –Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны гишүүн

Х.Эрдэнэцэцэг –Эмнэлгийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн хорооны тэргүүлэгч гишүүн

2.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн манлайлал, ур чадварын үнэлгээ хийх, үнэлгээний дүнд суурилан өөрсдийгөө хөгжүүлэх, хамт олны амжилтыг ахиулах хоёр сарын болзолт уралдааныг байгууллагын хэмжээнд зохион байгуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3.Тус болзолт уралдаанд хамт олноо удирдан, амжилттай оролцохыг Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс (Я.Эрдэнэтуяа), Нийгмийн эрүүл мэндийн төв (Б.Сарнай), Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ч.Оюунтунгалаг) нарт тус тус даалгасугай.

ДАРГА  Ч.ОЮУНАА



9031774 0719110006

Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны
05 дугаар сарын 02 ны/ний өдрийн
1/2 дугаар/дүгээр тушаалын
хавсралт



“АМЖИЛТАА АХИУЛАЯ-ХАМТДАА ҮЛГЭРЛЭЭ” БОЛЗОЛТ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Үндэслэл: Аймгийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар 2022 оныг Төрийн албаны “Ёс зүйг дээдлэх” зорилтот жил болгон зарласантай холбогдуулан төрийн албан хаагчийн, харилцаа, хандлага, ёс зүйг төлөвшүүлэх, төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг дээшлүүлэх, байгууллагын соёл, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх.

Зорилго: Төрийн албан хаагчийн харилцаа хандлагыг сайжруулах, ажлын байран дээр өөрийгөө хөгжүүлэх, бусдадаа эерэгээр нөлөөлөх, хамт олны амжилтыг ахиулах.

Зорилт:

- Хувь хүн өөрийгөө таних, ажлын төлөвлөлт, харилцаа хандлагаа сайжруулах
- Төрийн албан хаагчийн ёс зүйг дээдлэх, байгууллагын нэр төрийг эрхэмлэх
- Харилцан нөлөөлж, хамт олны манлайллыг нэмэгдүүлэх, хамтдаа хөгжих

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

1.Байгууллагын харилцаа, хандлагыг сайжруулах, өөрийгөө таних үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор харилцаа хандлага, төрийн албан хаагчийн алдаа дутагдлыг “Хаяггүй захидал”-аар хүлээн авч, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн манлайлал, ур чадварын хамт олны үнэлгээ хийж, хувь хүн бүр өөрийгөө хөгжүүлэх төлөвлөлтийг хийх,

2.Төрийн албан хаагч хувь хүн бүрийн харилцаа хандлага, ажлын цаг ашиглалт, төлөвлөлт, хариуцлага, хувцаслалтыг сайжруулах чиглэлээр өдөр бүрийн үнэлгээ бүхий хоёр сарын болзолт уралдаан зохион байгуулах,

3.“Бусдад тусалж, өөрийгөө хөгжүүлье” уриан дор хувь хүний хөгжил, биеэ авч явах соёл, хувцаслалт, захирах, захирагдах ёсны тухай илтгэл, лекцийг хамт олондоо танилцуулах,

4.Аймаг орон нутаг болон байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн ажилд идэвх санаачлагатай оролцож, бусдыгаа манлайлсан байх,

5.Аймаг орон нутгийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төсөл хөтөлбөр, өөрийн эрхэлсэн ажлаа чанарын өндөр түвшин хийж гүйцэтгэсэн байх,

6.Болзолт уралдааны хоёр сарын хугацаанд Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн төв, Эмнэлгийн тусламжийн хэлтэс хуваарьт өдрүүдэд төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, байгууллагын соёл, хувь хүний хөгжлийн чиглэлээр тодорхой ажил зохион байгуулна.

7.Уралдааныг дараах үзүүлэлтээр (1-5оноо) дүгнэнэ.

- Цаг ашиглалт,
- Хувцаслалт,
- Харилцаа хандлага,
- Олон нийтийн ажлын оролцоо,
- Үүрэг даалгаврын биелэлт,
- Бусдыгаа манлайлах,

Хугацаа:

Захиргаа удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс: 2022.05.02-2022.05.20.

Нийгмийн эрүүл мэндийн төв: 2022.05.23-2022.06.10.

Эмнэлгийн тусламжийн хэлтэс: 2022.06.13-2022.06.30

Болзолт уралдааны шагнал:

-Болзолт уралдааны дүнд сайн үзүүлэлтээр хамгийн өндөр оноо цуглуусан хамт олныг оны эхний хагас жилийн ажлын үзүүлэлтэд үндсэн цалингийн 40-60 хүртэл хувиар урамшуулна.

Хүлээгдэж буй үр дүн:

•Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, манлайлал, ур чадвар дээшилнэ.

•Байгууллагын соёл, ажилтан албан хаагчдын хувцаслалт, ажлын цаг ашиглалт сайжирна.

•Ажилтан бүрийн өөрийгөө хөгжүүлэх чадвар, хамт олны сайн сайхан байдал, эвсэг найрсаг харилцаа нэмэгдэнэ.

ooOoo